



ДУНДГОВЬ АЙМАГ
ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 27 өдөр

Дугаар А192

Сангиндалай

Өмнө нь гэр бүлийн хэрэгцээнд дундаа хамтран өмчилсөн газрыг гэр бүлийн нэг гишүүнд шилжүүлэх тухай

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 14 дүгээр зүйлийн 14.1.1, 14.1.3 дахь заалтууд, 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2 дахь заалт, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын 4 дүгээр зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрдэнэдалай сумын гэр хороололд 2008 оны 05 дугаар сарын 01-ээс өмнө гэр бүлийн хамтын хэрэгцээнд зориулан газар нэг удаа үнэгүй өмчилж гэр бүлийн гишүүд нэгэндээ газар өмчлөх эрхээ шилжүүлсэнтэй холбогдуулж газар өмчлөх эрх шилжүүлж авсан иргэний нэр, газрын байршил, хэмжээ үнэлгээг хавсралтаар баталсугай.

2. Энэ захирамж гарсантай холбогдуулж өмчилсөн газрын бүртгэлд өөрчлөлт оруулах, газар өмчлөх эрхээ шилжүүлсэн иргэдэд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар шинээр газар нэг удаа үнэгүй өмчлүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Газрын даамал (Э.Ууганцэцэг)-т үүрэг болгосугай.

3. Уг захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2005 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 41 дүгээр тоот захирамжийн 13 дахь хэсэг, 2005 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн 53 дугаар захирамжийн 58 дахь хэсгийг тус тус хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



БЛХАГВАМАНДАЛ

482302183